




БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



# МОНГОЛ УЛСЫН ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

21 АЙМАГ





- 1 21 аймгийн орон сууцны зах зээлийн ерөнхий мэдээлэл
- 2 21 аймгийн орон сууцны фонд, өрхүүдийн орон байрны нөхцөл
- 3 Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, ялгаатай байдлын анализ
- 4 Эрэлтийн судалгааны дэлгэрэнгүй үр дүн
  - Эрэлтийн судалгааны аргазүй
  - 21 аймгийн нийт өрхийн орон сууцны ирэх 5 жилийн эрэлт, хэрэгцээ
  - Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах өрхийн эрэлт, хэрэгцээ
  - Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны эрэлт, хэрэгцээ
  - Ойрын 3 жилийн инженерийн дэд бүтэц бүхий түрээсийн орон сууцны эрэлт, хэрэгцээ
  - Ойрын 3 жилийн хугацаанд дэд бүтэц бүхий хувийн сууц барих эрэлт, хэрэгцээ
- 5 Нийлүүлэлтийн судалгааны дэлгэрэнгүй үр дүн
  - Нийлүүлэлтийн судалгааны аргазүй
  - Нийтийн орон сууцны нийлүүлэлт
  - Амины орон сууцны нийлүүлэлт

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь 21 аймгийн нийт өрхийн ойрын 3 жилийн орон сууцны эрэлт хэрэгцээ, төсөл хэрэгжүүлэгчдийн ойрын 3 жилийн орон сууцны нийлүүлэлтийг тодорхойлж, орон сууцны талаар төрөөс баримтлах бодлого, төлөвлөлтийг боловсруулахад шаардлагатай суурь мэдээлэл бүрдүүлэхэд оршино.







**21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ЗАХ  
ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**



№	Байршил	МУ-ын ЗГ-ын 2016 оны 38-р ТОГТООЛ	МУ-ын ЗГ-ын 2016 оны 169-р ТОГТООЛ	НИЙТ
1	Дархан-Уул	83	69	152
2	Увс	84	21	105
3	Ховд	96	20	116
4	Архангай	120		120
5	Сэлэнгэ, Мандал	90	12	102
6	Хэнтий, Хэрлэн	96	24	120
7	Хэнтий, Бор-Өндөр	10		10
<b>НИЙТ</b>		<b>579</b>	<b>146</b>	<b>725</b>


“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2016 оны 38, 298, 169 дүгээр тогтоолоор нийт 1512 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлээд байгаа ба үүний 725 нь дээрхи аймгуудад хэрэгжсэн. Засгийн газрын 169 дүгээр тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын захиалгаар орон нутагт барьж ашиглалтад оруулсан 146 орон сууцыг түрээсэнд хамруулж, талбайн хэмжээг 70 хүртлэх м.кв болгон өөрчилсөн. Үүний дагуу Дархан-Уул, Хэнтий, Ховд, Увс аймгуудад захиалгаар бариулсан орон сууцны байруудыг тус тус түрээсэнд хамруулсан.



## ОРОН НУТГИЙН ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, Орон сууцны ангиллаар

Орон сууцны борлуулалтыг аймгуудаар авч үзвэл 2013-2018 онуудад 33,000 шинэ болон хуучин орон сууц худалдагдсан байна. Үүний 57%-ийг шинэ орон сууц, 43%-ийг хуучин орон сууц эзэлж байна.


Сүүлийн 5 жилийн борлуулалтын бууралт дундажаар 14%-ийн бууралттай байна. Энэхүү бууралтанд шинэ орон сууцны борлуулалтын нөлөө их байна. Шинэ орон сууцны борлуулалт 2016, 2017 онуудад 31%-иар буурсан байгаа бол, хуучин орон сууцны борлуулалт эдгээр онуудад 23%-иар өссөн үзүүлэлттэй байна.





## ОРОН НУТГИЙН ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, Талбайн хэмжээгээр

Борлогдсон орон сууцны талбайн хувьд шинэ орон сууцны 41-60м<sup>2</sup>, хуучин орон сууц 40м<sup>2</sup> хүртэл талбайтай орон сууцны борлуулалт их байна.






## ОРОН НУТГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН МЭДЭЭ, Сүүлийн 2 жилээр

2017 оны 12 сарын байдлаар ОНБ-уудын ипотекийн зээлийн үлдэгдлийг аймгуудаар авч үзвэл Орхон аймагт 15.7 хувь, Дархан-Уул аймагт 15.4 хувь, Дорноговь аймагт 9.0 хувь, Дорнод аймагт 7.4 хувь, Ховд аймагт 5.4, Увс аймагт 5.4 хувь нь ногдож байгаа бөгөөд эдгээр нь ОНБ-уудын салбарын нийт ипотекийн зээлийн 58.3 хувийг бүрдүүлж байна.

### Нийт зээлийн үлдэгдэл 765.7 тэрбум төгрөг








## ОРОН НУТГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, Сүүлийн 2 жилээр

2017 оны байдлаар орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл **765.7 тэрбум** төгрөгт харин **зээлдэгчдийн тоо 25.2 мянгад** хүрчээ.

Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 18.0 хувь харин нийт зээлдэгчдийн 27.0 хувийг эзэлж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 35.6 тэрбум төгрөгийн зээл шинээр олгож, 2.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэв.

### Нийт зээлдэгчийн тоо 25,2 мянга









**21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ФОНД,  
ӨРХҮҮДИЙН ОРОН  
БАЙРНЫ НӨХЦӨЛ**



Монгол улсын 21 аймагт 1955 оноос 2017 оны хооронд ашиглалтанд орсон, ашиглагдаж байгаа 57,000 айлын орон сууц байгаа ба үүний 0,7% нь хувийн сууц байна. Цаашид 2018-2020 онд аймгуудад 10,773 айлын орон сууц нэмж ашиглалтанд орохоор төлөвлөгдсөн байна.



2017 оны байдлаар 21 аймгийн нийт өрхийн тоо 482,687 байгаа ба үүний 41% буюу 198,302 өрх нь аймгуудын төвд байна. Эдгээр өрхийн тоог бүсүүдэд ангилвал:



Эх сурвалж: ҮСХ





# 21 АЙМГИЙН ТӨВИЙН ӨРХҮҮДИЙН ОДООГИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ



**198,302**  
21 АЙМГИЙН  
ТӨВИЙН ӨРХИЙН  
ТОО

**29%**  
57,377 ӨРХ  
ОРОН СУУЦАНД



**71%**  
140,925 ӨРХ  
ГЭР ХОРООЛОЛД



**67,766-34%**  
ХАНГАЙН БҮСИЙН АЙМГИЙН  
ТӨВҮҮДИЙН НИЙТ ӨРХИЙН ТОО

**68,078-34%**  
ТӨВИЙН БҮСИЙН АЙМГИЙН  
ТӨВҮҮДИЙН НИЙТ ӨРХИЙН ТОО

**27,442-14%**  
ЗҮҮН БҮСИЙН АЙМГИЙН  
ТӨВҮҮДИЙН НИЙТ ӨРХИЙН ТОО

**35,016-18%**  
ТӨВИЙН БҮСИЙН АЙМГИЙН  
ТӨВҮҮДИЙН НИЙТ ӨРХИЙН ТОО



	Орон сууцанд амьдардаг		Гэр хороололд амьдардаг	
	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь
Баруун бүс	18949	20%	48817	80%
Хангай бүс	24279	28%	43799	72%
Төвийн бүс	7047	36%	27969	64%
Зүүн бүс	7102	26%	20340	74%
<b>НИЙТ</b>	<b>57,377</b>	<b>29%</b>	<b>140,925</b>	<b>71%</b>





21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ,  
НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦВЭР






# ОРОН СУУЦНЫ ОЙРЫН 3 ЖИЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦВЭР, оноор



ОЙРЫН 3 ЖИЛД

**967**


СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ИЛҮҮДЭЛ БАЙНА





ТЭНХЛЭГ ЗУУЧ  
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ


## ОРОН СУУЦНЫ ОЙРЫН 3 ЖИЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦВЭР, 21 АЙМАГ



21 аймгаас 8 аймаг нь нийлүүлэлтийн илүүдэлтэй, бусад нь эрэлтийн илүүдэлтэй байна. Аймаг бүрийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг дараагийн хуудсуудад дэлгэрэнгүй харуулна.




# 21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦВЭР, өрөөний тоогоор








# 21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЭНЦВЭР, Талбайн хэмжээгээр






## БАРУУН БҮС



■ Төсөл хэрэгжүүлэгчдийн санал болгож буй дундаж үнэ  
■ Өрхүүдийн хүсч буй дундаж үнэ

## ХАНГАЙН БҮС




■ Өрхүүдийн хүсч буй дундаж үнэ






# 21 АЙМГИЙН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ТЭНЦВЭР, бүсээр

## ТӨВИЙН БҮС



- Өрхүүдийн хүсч буй дундаж үнэ
- Төсөл хэрэгжүүлэгчдийн санал болгож буй дундаж үнэ

## ЗҮҮН БҮС



- Төсөл хэрэгжүүлэгчдийн санал болгож буй дундаж үнэ
- Өрхүүдийн хүсч буй дундаж үнэ






**21 АЙМГИЙН ТӨВИЙН ЭРЭЛТИЙН  
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН**





# ТҮҮВРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ТАРХАЛТ





$$h = S + K + iK$$

$$K = \frac{N}{n}$$

$$i = 1, 2, 3 \dots n$$

Энд:


- $n$  – Тухайн хорооноос судалгаа авах өрхийн тоо
- $N$  – Эх олонлогийн тоо. ӨХ тухайн хорооны өрхийн тоо
- $S$  – Санамсаргүй эхлэх цэг
- $K$  – Алхам (интервал)

Сонгогдсон байршилд баг хороо тус бүрээс авах судалгааны тоо өгөгдсөн байна. Судалгаанд хамруулах өрхийг сонгохдоо хороо, баг бүр дээр эхлэлийн цэг болгож нэг өрхийг сонгох бөгөөд дараагийн өрхийг сонгохдоо 5 айлыг буюу хашаа, хаалгыг алгасан 6 дах өрхөд зочлох байдлаар сонгосон. Өөрөөр хэлбэл 1 дэх, 6 дах, 11 дэх, 16 дах өрхөөр гэх байдлаар зочилж судалгааг авсан. Хэрэв сонгогдсон өрх эзэнгүй эсвэл гэрийн эзэн болон гэрийн эзэгтэй байхгүй тохиолдолд дараагийн тоот өрхийг сонгосон. Эхлэлийн цэг болох өрх нь тухайн багийн эхний тоот гудамж/байрны 1 тоот өрх болно.


\*Гэр болон байшинд амьдардаг өрхийн судалгаанд хамруулах тоог алдагдуулахгүй бөгөөд хэрэв гэрт эсвэл байшинд амьдардаг өрхийн тоо гүйцсэн тохиолдолд тухайн төрлийн сууцанд амьдардаг өрхөд зочлох шаардлагагүй.



Төлөөлөх чадваргүй түүвэр



Төлөөлөх чадвартай түүвэр






## МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЯНАЛТ

Судалгааны төслийн багийн зүгээс CPro программын windows хувилбар дээр тоон судалгааны мэдээллийг шивж оруулах, шалгах программыг бэлтгэсэн. CPro (Census and Survey Processing System) программыг АНУ-ын Тооллогын товчоо (US Census Bureau) гаргасан бөгөөд үнэгүй ашиглах боломжтой программ юм. Энэхүү программаар мэдээллийг оруулах, шалгах засварлах, мэдээллийн сан үүсгэх, программыг өөрийн судалгааны асуулгадаа тохируулан хэрэглэгч өөрсдөө боловсруулах боломжтой байдаг. Ийнхүү компьютер дээр бэлэн болсон программаа Android системрүү хөрвүүлж, мэдээлэл цуглуулалтын ТАБЛЕТ-руу шилжүүлж суулгасан. Программыг ийнхүү ашигласнаар мэдээллийн бүрэн дүүрэн, алдаагүй байдлыг бүрэн хянах боломжтой болсон юм.

### Мэдээлэл цуглуулалтын хэрэгсэл / Samsung Tablet E/



### Мэдээлэл цуглуулах төхөөрөмж, харагдах байдал





Судалгааны мэдээлэл цуглуулалтыг бид асуулга судалгааны арга (**FACE TO FACE INTERVIEW**)-аар авсан. Энэ нь судалгаанд оролцогчдоос чанартай мэдээллийг олж авахад илүү чухал үүрэгтэй. Ингэхдээ “СAPI” буюу таблет төхөөрөмж дээр мэдээлэл цуглуулсан. Энэ арга нь тоон судалгааны бөглөлтийн бүрэн бүтэн байдал, логик алдаа гэх зэргийг бууруулж, судалгаа авч байх явцад хянах бүрэн боломжтой байдгаараа цаасан аргаар судалгаа авахаас давуу талтай.

## ЧАНАРЫН ХЯНАЛТ

✓ Бөглөлт, логик уялдаа шалгах  
**100%**



✓ Утсаар хяналт  
**100%**



✓ Талбар дээрх хяналт  
**50%**



## ШҮҮЛТҮҮР

### Судалгаанд оролцох өрхийг сонгох шүүлтүүр:

- Эмэгтэй, эрэгтэй 18-с дээш насны
- Тухайн өрхийн, өрхийн тэргүүн, эхнэр эсвэл тухайн өрхөд голлох шийдвэр гаргадаг бусад гишүүн
- Улаанбаатар хотод, тухайн байршил, өрхөд амьдардаг
- Одоогийн амьдарч буй сууцаа өөрчлөх, солих, шинээр худалдаж авах, засаж сайжруулах хэрэгцээтэй өрх





**Мэдээлэл боловсруулалт:** Судалгааны анхдагч мэдээллийг CPro программ дээр шалгалт хийж цэвэрлэсний дараа мэдээллийн бүтцийг өөрчилж, статистикийн шинжилгээний SPSS-21.0 программыг ашиглан мэдээллийн санд дүн шинжилгээ хийсэн.

Боловсруулалт хийхдээ хувьсагч хооронд дан болон харьцуулсан тоололт хийн, хи квадрат тестээр статистик ач холбогдлыг давхар шалгасан. Түүнчлэн логик шинжилгээ, олон хүчин зүйлийн шинжилгээ хийж, хувьсагч хоорондын хамаарал, хамаарлын ач холбогдлыг үнэлсэны.








# 21 АЙМГИЙН ТӨВИЙН ӨРХҮҮДИЙН 3-5 ЖИЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ






## 21 АЙМГИЙН ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ /НИЙТ ДҮНГЭЭР/





# 21 АЙМГИЙН ТӨВИЙН БОЛОН НИЙТ ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ /ОНООР, БҮСЭЭР/







ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦ  
ХУДАЛДАН АВАХ ӨРХИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ  
/ИРЭХ 5 ЖИЛД/





## 21 АЙМГИЙН ТӨВИЙН ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ /НИЙТ ДҮНГЭЭР/




ТЭНХЛЭГ ЗУУЧ  
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ 121,929 ӨРХ	ДЭД БҮТЭЦ БҮХИЙ СУУЦ БАРИХ 37,266 ӨРХ
ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ 32,048 ӨРХ	ОГТ ХЭРЭГЦЭЭГҮЙ 32,978 ӨРХ
ХАШАА БАЙШИН ХУДАЛДАЖ АВАХ 13,594 ӨРХ	АОС-ХАУС ХУДАЛДАЖ АВАХ 18,046 ӨРХ



## 21 АЙМГИЙН ТӨВИЙН НИЙТ ӨРХҮҮДИЙН ИРЭХ 5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ



Гэр хороололд амьдарч буй өрхийн тоо **107,985 өрх**  
Орон сууцанд амьдарч буй өрхийн тоо **13,944 өрх**



## 21 АЙМГИЙН ТӨВИЙН НИЙТ ӨРХҮҮДИЙН ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ХЭРЭГЦЭЭ /ӨРХИЙН ТООГООР/







## 21 АЙМГИЙН ТӨВИЙН ОДООГИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

21 аймгийн төвийн нийт өрхийн **121,929** өрхөд шинээр орон сууц худалдаж авах хэрэгцээ байгаа бөгөөд, шинээр инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдаж авах хэрэгцээтэй өрхүүдийн 53 хувь буюу 64,807 өрх нь дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд амьдарч байна.



ХЭРЭГЦЭЭТЭЙ  
БАЙГАА

**121,929**  
ӨРХ

ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДООГҮЙ  
ХАШАА БАЙШИН

**53%**  
**64,807 ӨРХ**

МОНГОЛ ГЭР

**25%**  
**30,559 ӨРХ**

НИЙТИЙН ОРОН СУУЦ

**12%**  
**13,944 ӨРХ**


ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДСОН ХАШАА  
БАЙШИН, АОС

**10%**  
**12,619 ӨРХ**



## 21 АЙМГИЙН ТӨВИЙН ӨРХҮҮДИЙН ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ХЭРЭГЦЭЭ /БАЙРШЛААР/

21 аймгийн төвийн өрхүүдийн 118,856 өрх нь шинээр худалдаж авах инженерийн дэд бүтэц бүхий орон сууцаа одоо амьдарч буй аймгийн төвд авах сонирхолтой байгаа ба, 17,122 өрх нь өөр аймгийн төвд худалдан авах сонирхолтой байна. Улаанбаатар худалдан авах сонирхолтой нийт 29,060 өрх байгаа бөгөөд эдгээр өрхийн 6,133 өрх нь Баянзүрх дүүрэгт худалдан авах хэрэгцээтэй байна.





# ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ЗОРИЛГО, НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛ



ТЭНХЛЭГ ЗУУЧ  
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

## Худалдан авах зорилго







## Нөлөөлдөг хүчин зүйл







# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮДИЙН СОНИРХОЖ БУЙ СОНГОЛТУУД





## 21 АЙМГИЙН ӨРХҮҮДИЙН ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР БҮРДҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР



ТЭНХЛЭГ ЗУУЧ  
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

### Төлбөрийн нөхцөл



### Урьдчилгаа бүрдүүлэх эх үүсвэр



Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах сонирхолтой нийт өрхүүдийн 78,654 өрх нь "урьдчилгаа төлбөрөө төлж, үлдсэн төлбөрөө арилжааны банкны ипотекийн зээл"-нд хамрагдах хүсэлтэй байгаа бөгөөд энэ нь нийт хэрэгцээтэй өрхийн 54 хувийг эзэлж байна. Эдгээр өрхүүд урьдчилгаа төлбөрөө 1-рт өөрсдийн хуримтлалаас бүрдүүлэх, 2-рт цалин тэтгэврийн зээл авч бүрдүүлэх хэрэгцээтэй байна. 21 аймгийн төвийн өрхүүд мөн өөрсдийн эзэмшлийн газраа байраар солих хүсэлтэй байна.




## ИПОТЕКИЙН ЗЭЭЛЭНД ХАМРАГДАХ ХҮСЭЛТЭЙ ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хотод ирэх 5 жилийн хугацаанд нийт **121,929** өрхөд шинээр инженерийн дэд бүтэц бүхий орон сууцны эрэлт хэрэгцээ байгаа бөгөөд эдгээр өрхүүдийн 78,644 өрх нь ипотекийн зээлэнд хамрагдах хүсэлтэй байна. 2018 онд нийт өрхийн 18,433 өрх, 2019 онд 22,703 өрх, 2020 онд 23,337 өрх, 2021 онд 8,887 өрх, 2022 он болон түүнээс цааш онд 5,284 өрх нь зээлэнд хамрагдан орон сууцтай болох хүсэлтэй байна.




Ирэх 5 жилийн хугацаанд  
Улаанбаатар хотын хэмжээнд  
нийт **78,644** өрх ипотекийн  
зээлэнд хамрагдах хүсэлтэй  
байна.







# ИПОТЕКИЙН ЗЭЭЛЭНД ХАМРАГДАХ ХҮСЭЛТЭЙ НИЙТ ӨРХҮҮДИЙН БОЛОМЖИТ ХУВИЛБАР



Ипотекийн зээлэнд хамрагдах хүсэлтэй нийт өрхүүдийн хувьд дунджаар 61м2 талбайтай байрыг 1м2-ийн үнэ 1,022,938 төгрөгөөр худалдан авах сонирхол өндөр байна. Энэхүү сууцаа 15 жилийн хугацаатай, урьдчилгаа төлбөр 23 хувь буюу 14,351,850 төгрөгийг төлөн сар бүр 459,166 төгрөг төлөхөөр төлөвлөж байна.



## ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАЖ БУЙ НИЙТ ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ /30%/

Урьдчилгаа 30 болон түүнээс дээш хувь төлөх боломжтой нийт өрхийн тоо;

**23,849**  
өрх

Өрхөд НДШ төлөгч байх;

**61,899**  
өрх

Өрхийн татварын өмнөх орлогын 45 хувь нь зээлийн сар бүрийн төлбөрийг төлж хүрэлцэхүйц байх;

**29,727**  
өрх

Худалдан авах нийт талбайн хэмжээ 80м<sup>2</sup>-аас хэтрэхгүй байх;

**74,321**  
өрх

Худалдан авах чадвараар баталгаажсан нийт өрхийн тоо	Өрхийн тоо
2018 онд	849
2019 онд	3,400
2020 онд	4,266
2021 онд	1,011
2022 он болон түүнээс цааш	2,212
<b>Нийт</b>	<b>11,738</b>

Ипотекийн зээлийн худалдан авах чадвараар баталгаажсан нийт 11,738 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдээс 2020 онд 4,266 өрх нь бусад онуудаас хамгийн их чадвартай гэсэн үр дүн гарсан байна.



ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАЖ БУЙ  
НИЙТ ӨРХ

**ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦАААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛЭЭР  
ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТАЙ**

**11,738 ӨРХ**







## ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАЖ БУЙ НИЙТ ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ /25%/

Урьдчилгаа 25 болон түүнээс дээш хувь төлөх боломжтой нийт өрхийн тоо;

**23,849**  
өрх

Өрхөд НДШ төлөгч байх;

**61,899**  
өрх

Өрхийн татварын өмнөх орлогын 45 хувь нь зээлийн сар бүрийн төлбөрийг төлж хүрэлцэхүйц байх;

**29,727**  
өрх

Худалдан авах нийт талбайн хэмжээ 80м<sup>2</sup>-аас хэтрэхгүй байх;

**74,321**  
өрх

Худалдан авах чадвараар баталгаажсан нийт өрхийн тоо	Өрхийн тоо
2018 онд	4,328
2019 онд	4,069
2020 онд	4,311
2021 онд	1,359
2022 он болон түүнээс цааш	2,212
<b>Нийт</b>	<b>16,279</b>

Ипотекийн зээлийн худалдан авах чадвараар баталгаажсан нийт 16,279 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдээс 2020 онд 4,311өрх нь бусад онуудаас хамгийн их чадвартай гэсэн үр дүн гарсан байна.



## ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГАЖ БУЙ НИЙТ ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ /20%/

Урьдчилгаа 20 болон түүнээс дээш хувь төлөх боломжтой нийт өрхийн тоо;

**23,849**  
өрх

Өрхөд НДШ төлөгч байх;

**61,899**  
өрх

Өрхийн татварын өмнөх орлогын 45 хувь нь зээлийн сар бүрийн төлбөрийг төлж хүрэлцэхүйц байх;

**29,727**  
өрх

Худалдан авах нийт талбайн хэмжээ 80м<sup>2</sup>-аас хэтрэхгүй байх;


**74,321**  
өрх

Худалдан авах чадвараар баталгаажсан нийт өрхийн тоо	Өрхийн тоо
2018 онд	4,347
2019 онд	6,635
2020 онд	4,952
2021 онд	1,404
2022 он болон түүнээс цааш	2,212
<b>Нийт</b>	<b>19,550</b>

Ипотекийн зээлийн худалдан авах чадвараар баталгаажсан нийт 19,550 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдээс 2019 онд 6,635 өрх нь бусад онуудаас хамгийн их чадвартай гэсэн үр дүн гарсан байна.



## ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ШАЛГУУР ХАНГААГҮЙ ӨРХИЙН ТОО /5 ЖИЛЭЭР/



Худалдан авах чадвараар баталгаажсан нийт өрхийн тоо	Өрхийн тоо
2018 онд	17,584
2019 онд	19,303
2020 онд	19,071
2021 онд	7,876
2022 он болон түүнээс цааш	3,072
<b>Нийт</b>	<b>66,906</b>

Ипотекийн зээлийн шалгуур нөхцөлийг хангаж чадаагүй нийт 66,906 өрх байгаа бөгөөд нь энэ нь нийт зээлэнд хамрагдах хэрэгцээтэй өрхийн 85 хувийг эзлэж байна.





## БЭЛЭН МӨНГӨӨР ХУДАЛДАЖ АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ӨРХҮҮДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах хэрэгцээтэй нийт өрхийн **8,819** өрх ирэх 5 жилд бэлэн мөнгөөр худалдан авах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эдгээр өрхийг өрхийн орлого, орлогын эх үүсвэрийн тоо, өрхийн хуримтлал зэрэг тодорхой үзүүлэлтүүдээр шүүлтүүр хийж үзэхэд 11 хувь буюу 908 өрх орон сууц худалдаж авах чадвартай гэсэн үр дүн гарсан.


- ✓ 2018 онд нийт өрхийн 3,507 өрхөд хэрэгцээтэй байсан бол энэ онд худалдан авах чадвараар баталгаажсан 720 өрх байна.
- ✓ 2019 онд нийт өрхийн 318 өрх буюу 4 хувьд нь хэрэгцээтэй байсан бол энэ онд ямар ч өрх худалдан авах чадвараар баталгаажсаагүй байна.



**ГЭР ХОРООЛОЛД  
7,911 ӨРХ**



**ОРОН СУУЦАНД  
908 ӨРХ**




**3,167  
өрх**  
Худалдан авах  
чадвартай

Нийт хэрэгцээтэй өрх Худалдан авах чадвартай өрх




## МӨНГӨН ТӨЛБӨРӨӨР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ

ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛ (11,738)  
болон  
БЭЛЭН МӨНГӨӨР (3,167) ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТАЙ  
**14,905** ӨРХ






# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТАЙ ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



## ӨРХИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

АМ БҮЛИЙН МЭДЭЭЛЭЛ



**4,0 хүн**

1 ӨРХӨД АМЬДАРЧ БУЙ  
ӨРХИЙН ТОО



**1 өрх**

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ  
ТОО



**1,8 хүн**

ГАДААДАД АЖИЛЛАЖ БАЙГАА  
ГИШҮҮН БАЙГАА ЭСЭХ



**8%**



## САНХҮҮГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨРХИЙН 1 САРЫН  
ДУНДАЖ ОРЛОГО



**1,168,454₮**

ХУРИМТЛАЛ



**51%**

ЗЭЭЛ



**34%** зээлтэй

БУСАД ХӨРӨНГӨ




**70%**






# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРГҮЙ ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



## ӨРХИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

АМ БҮЛИЙН МЭДЭЭЛЭЛ



**4,8 хүн**

1 ӨРХӨД АМЬДАРЧ БУЙ  
ӨРХИЙН ТОО



**1,2 өрх**

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ  
ТОО



**1,8 хүн**

ГАДААДАД АЖИЛЛАЖ БАЙГАА  
ГИШҮҮН БАЙГАА ЭСЭХ



**6%**



## САНХҮҮГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨРХИЙН 1 САРЫН  
ДУНДАЖ ОРЛОГО



**802,675₮**

ХУРИМТЛАЛ



**10%**

ЗЭЭЛ



**64%** зээлтэй

БУСАД ХӨРӨНГӨ




**18%**



## ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТТЭЙ ӨРХ, БАЙРШЛААР


Орон сууц худалдан авах чадвартай өрхүүдийн одоогийн амьдарч буй байршлыг харахад хамгийн их хувь нь буюу 2 мянган өрх Хөвсгөл аймгийн төвд байна. Энэ нь Хөвсгөл аймгийн төвд орон сууц худалдан авах хэрэгцээтэй өрх олон байгаатай салшгүй холбоотой юм. Харин дараагаар нь Хэнтий болон, Дорнод аймагт инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах хэрэгцээтэй байна.






# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ, ОРОН СУУЦНЫ ШИНЖ ЧАНАРААР


## ӨРӨӨНИЙ СОНГОЛТ




## ТАЛБАЙН ХЭМЖЭЭ



## БАРИЛГЫН ХИЙЦ



## ХУДАЛДАН АВАН СОНИРХОЛТОЙ БАЙРШИЛ





**МӨНГӨН БУС ТӨЛБӨРӨӨР  
БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ буюу ЭРЭЛТ НЭМЖ  
БИЙ БОЛОХ БОЛОМЖ**





# ӨӨРИЙН ӨМЧЛӨЛИЙН ГАЗРЫГ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРТ ТООЦУУЛАХ ӨРХҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Газрын дундаж талбайн хэмжээ

740м<sup>2</sup>

Газрыг үнэлэх дундаж үнэ

17,168,103₮

Газрын эзэмшлийн хэлбэр

Хувийн өмч-84%  
Төлбөргүй амьдардаг-16%

Бусад ҮХХ байгаа эсэх


12% нь 2 дахь  
болон 3 дахь ҮХХ  
ЭЗЭМШДЭГ.

Одоогийн амьдарч байгаа газрын хувьд дунджаар 740м<sup>2</sup> буюу 0,7 га газар дээр амьдарч байгаа бөгөөд эзэмшлийн хувьд 84 хувь нь өмчлөлийн хэлбэртэй байна. Одоогийн амьдарч буй газраа өнөөдрийн үнэ ханшаар үнэлбэл нийт дүн 17,168,103 төгрөгөөр үнэлэж байна.



# ӨӨРИЙН ӨМЧЛӨЛИЙН ГАЗРЫГ ОРОН СУУЦААР СОЛИХ СОНИРХОЛТОЙ БАЙГАА ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

- ✓ Өөрийн өмчлөлийн газрыг орон сууцаар солих хүсэлтэй нийт **19,318** өрх байна. Эдгээр өрхөөс газраа урьдчилгаа төлбөрт тооцуулах боломжтой нийт 16,150 өрх байнаа бөгөөд эдгээр өрхийн 34 хувь нь 0,7 га ба түүнээс бага талбайтай байгаа бөгөөд, 66 хувь 0,7 га талбайгаас их байна.
- ✓ 21 аймгийн төвийн нийт өрхүүдээс Орхон аймгийн төвийн нийт 5,498 өрх нь газраа солих хүсэлтэй тэр дундаа худалдан авах чадвараар баталгаажсан байна.



Газраа солих өрхүүд /Байршлаар/



**16,150 өрх**  
Худалдан авах чадвараар баталгаажсан



ТЭНХЛЭГ ЗУУЧ  
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

**МӨНГӨН  
ТӨЛБӨРӨӨР  
БАТАЛГААЖСАН  
ЭРЭЛТ**

ИРЭХ 5 ЖИЛИЙН  
ХУГАЦААНД ИПОТЕКИЙН  
ЗЭЭЛ **11,738** өрх


БЭЛЭН МӨНГӨӨР  
ХУДАЛДАН АВАХ  
ЧАДВАРТАЙ **3,167** ӨРХ

**14,905  
ӨРХ**

**НИЙТ  
31,055  
ӨРХ**

**МӨНГӨН БУСААР  
ТӨЛБӨРӨӨР  
БАТАЛГААЖСАН  
ЭРЭЛТ**

ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗРАА  
УРЬДЧИЛГААНД ӨГӨХ  
**16,150 ӨРХ**





ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН  
СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ, ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР  
БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ





## 21 АЙМГИЙН ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ /НИЙТ ДҮНГЭЭР/

ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ 121,929 ӨРХ	ДЭД БҮТЭЦ БҮХИЙ СУУЦ БАРИХ 37,266 ӨРХ
ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ 32,048 ӨРХ	ОГТ ХЭРЭГЦЭЭГҮЙ 32,978 ӨРХ
ХАШАА БАЙШИН ХУДАЛДАЖ АВАХ 13,594 ӨРХ	АОС-ХАУС ХУДАЛДАЖ АВАХ 18,046 ӨРХ




# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ /5 ЖИЛЭЭР/



ХЭРЭГЦЭЭТЭЙ  
БАЙГАА

**18,046**  
ӨРХ






## ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙГАА ӨРХИЙН ОДООГИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хэрэгцээтэй нийт 18,046 өрх байгаа бөгөөд үүний 31 хувь нь инженерийн дэд бүтэц бүхий нийтийн орон сууцанд, 38 хувь нь уламжлалт аргаар шийдсэн дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд, 26 хувь нь гэр хороололд монгол гэрт, үлдсэн 5 хувь нь дэд бүтцэд холбогдсон хашаа байшинд амьдарч байна.





## ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХУДАЛДАН АВАХ ЗОРИЛГО, БАЙРШИЛ /ӨРХИЙН ТООГООР/



Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хэрэгцээтэй байгаа өрхүүдийн шинээр сууц худалдан авах гол зорилго нь 1-рт өрхийн сууцны нөхцөлөө сайжруулах, 2-рт гадна орчин нөхцөлаа сайжруулах, 3-рт зай талбайгаа томруулах зорилготой байна. Байршлийн хувьд нийт өрхийн 14,294 өрх нь тухайн амьдарч буй аймгийн төвд худалдан авах сонирхолтой байгаа бол, дараагаар нь одоо амьдарч байгаа аймгийн аль нэг суманд авах сонирхол илүү байна.





# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХУДАЛДАЖ АВАХАД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛ




Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууц худалдан авахад 1-рт барилгын чанар, 2-рт барилгын байршил, 3-рт үнэ байна. Харин нийт өрхүүдийн хувьд дангаараа төлөвлөгдсөн амины орон сууцыг худалдан авах сонирхолтой байна.





# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ

## Өрөөний тоо



## Талбайн сонголт





# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙГАА ӨРХИЙН ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ



**Худалдаж авах боломжтой үнэ**

**1M<sup>2</sup>**

**Дундаж үнэ**  
**1,265,231₮**



# ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙГАА ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## АМ БҮЛИЙН ТОО

4.0

Дундаж ам  
бүлийн тоо

2.2

0-17 насны  
хүүхэдтэй

## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ ДУНДАЖ НАС

39


Орон сууц түрээслэхээр сонирхож буй нийт өрхүүдийн, өрхийн тэргүүний дундаж нас 39 байна.

## ЦАЛИН ХӨЛСТЭЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ ТОО

1.8

Өрхийн нийт цалин хөлстэй ажил эрхэлдэг гишүүдийн тоо 1,8 байгаа бөгөөд энэ нь


## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛ ЭРХЛЭЛТ








## ИРЭХ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН НИЙТ ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ



### ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ӨРХИЙН ТОО



Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хэрэгцээтэй байгаа нийт өрхүүдийн **1,245** өрх нь буюу 7 хувь нь худалдан авах чадвартай гэж гарсан ба энэхүү тооцооллыг хийхэд тухайн өрхийн 1 сарын орлого нь 3 ба түүнээс дээш сая төгрөг байх, 3 ба түүнээс дээш эх үүсвэрээс орлого олдог байх, хуримтлалтай байх гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг авч үзсэн болно.



ТЭНХЛЭГ ЗУУЧ  
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

ОЙРЫН 3 ЖИЛИЙН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ  
БҮХИЙ ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ  
ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ




## 21 АЙМГИЙН ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ /НИЙТ ДҮНГЭЭР/

ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ 121,929 ӨРХ	ДЭД БҮТЭЦ БҮХИЙ СУУЦ БАРИХ 37,266 ӨРХ
ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ 32,048 ӨРХ	ОГТ ХЭРЭГЦЭЭГҮЙ 32,978 ӨРХ
ХАШАА БАЙШИН ХУДАЛДАЖ АВАХ 13,594 ӨРХ	АОС-ХАУС ХУДАЛДАЖ АВАХ 18,046 ӨРХ



# ИРЭХ 3 ЖИЛД ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭ







ТЭНХЛЭГ ЗУУЧ  
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

## ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй байгаа нийт **32,048** өрх байна. Орон сууц түрээслэх сонирхолтой нийт өрхүүдийн 3,859 өрх нь нийтийн орон сууцанд, 12,729 өрх нь дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд, 13,196 өрх нь монгол гэрт, 2,264 өрх нь дэд бүтцэд холбогдсон хашаа байшин, АОС-нд амьдарч байна. Нийт түрээслэх хэрэгцээтэй байгаа өрхийн 1,752 өрх нь тухайн амьдарч буй сууцаа түрээлэж амьдардаг бол 737 өрх нь төлбөргүйгээр бусдын өмчлөлийн байранд төлбөргүйгээр амьдарч байна.





# ИРЭХ 3 ЖИЛД ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮД, ЗОРИЛТОТ БҮЛГЭЭР

## АЛЬ НЭГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ХАМРАГДАЖ БАЙГАА ЭСЭХ



## ТҮРЭЭСЛЭХ ШАЛТГААН




Ирэх 3 жилийн хугацаанд инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хүсэлтэй нийт 32,048 өрх байгаа юм. Үүнээс 29,3 хувь нь "гэр бүлийн бусад гишүүдийн хэрэгцээнд зориулж", 27,1 хувь нь "өөрийн өмчлөлийн сууцгүй" гэсэн шалтгаанаар түрээслэх сонирхолтой байна. Харин эдгээр өрхүүдийн 40,3 хувь нь "залуу гэр бүл", 21,6 хувь нь төрийн албан хаагч байна.



## ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮДИЙН СОНИРХОЖ БУЙ БАЙРШИЛ/ӨРХИЙН ТООГООР/


Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй байгаа нийт өрхийн 22,474 өрх нь одоогийн амьдарч байгаа аймгийн төвд түрээслэх сонирхолтой байгаа бол дараагаар нь өөр аймгийн төвд түрээслэхээр сонирхож байна. Харин Улаанбаатар хотод түрээслэх хэрэгцээтэй байгаа өрхийн 1,553 өрх нь Баянзүрх дүүрэгт, 1,475 өрх нь Баянгол дүүрэгт түрээслэх хэрэгцээтэй байна.






# ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХ


## М2-ИЙН ХЭМЖЭЭ




## ӨРӨӨНИЙ ТОО



## ТҮРЭЭСЛЭХ ХУГАЦАА



## Түрээслэж байх явцдаа өөрийн эзэмшлийнх болгох сонирхол




Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хүсэлтэй нийт өрхүүд дунджаар 31-50м² талбаатай 2 өрөө байрыг, 4-5 жилийн хугацаатай түрээслэн өөрийн болгох сонирхолтой байна.




## ТҮРЭЭСЛЭХ ӨРӨӨНИЙ СОНГОЛТ, БОЛОМЖИТ ҮНЭ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй нийт өрхийн хувьд 1 өрөө байрыг дунджаар 201,000-300,000 төгрөгөөр түрээслэх хүсэлтэй 20,042 өрх байгаа бол, 2 өрөө байрыг мөн адил үнээр түрээслэх хүсэлтэй байна. Харин 3 өрөө байрыг 301,000-400,000 төгрөгөөр түрээслэх хүсэлтэй 19,248 өрх байна.

	200,000₮ хүртэлх	201,000- 300,000₮	301,000- 400,000₮	401,000- 500,000₮	500,000₮ дээш
1 өрөө	<b>20,042</b>	<b>8,266</b>	<b>3,740</b>	-	-
2 өрөө	<b>18,247</b>	<b>6,454</b>	<b>3,247</b>	<b>2,987</b>	<b>1,113</b>
3 өрөө	<b>3,986</b>	<b>6,247</b>	<b>19,248</b>	<b>1,566</b>	<b>1,001</b>






## ТҮРЭЭСЛЭХ БОЛОМЖТОЙ ҮНЭ, СОНГОЛТОНД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛ

Үзүүлэлтүүд	1 өрөө	2 өрөө	3 өрөө
Түрээслэх м2	32,1	45,3	60,0
1м2 талбайг түрээслэх үнэ	4,298₮	4,523	4,623
Нийт үнэ	137,966₮	204,892₮	277,380

1 өрөө 32,1м2 талбайтай байрыг 1м2-ийн үнийг 4,298 төгрөгөөр, нийт үнийн дүн 137,966 төгрөгөөр түрээслэх хэрэгцээтэй байна.

2 өрөө 45,3м2 талбайтай байрыг 1м2-ийн үнийг 4,523 төгрөгөөр, нийт үнийн дүн 204,892 төгрөг,

3 өрөө байрыг 60,0м2 талбайг 1м2-ийн үнийг 4,623 төгрөгөөр нийт үнийн дүн 277,380 төгрөг байхаар сонирхож байна.





# ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## АМ БҮЛИЙН ТОО

3.8

Дундаж ам  
бүлийн тоо

2.0

0-17 насны  
хүүхэдтэй

## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ ДУНДАЖ НАС

39.2

Орон сууц түрээслэхээр сонирхож буй нийт өрхүүдийн, өрхийн тэргүүний дундаж нас 39.2 байна.

## ЦАЛИН ХӨЛСТЭЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ ТОО

1.0

Өрхийн нийт цалин хөлстэй ажил эрхэлдэг гишүүдийн тоо 1,0 байгаа бөгөөд энэ нь

## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛ ЭРХЛЭЛТ





## ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭН АМЬДАРДАГ ӨРХҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ /4,724 өрх/

ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ
Нийт ам бүлийн тоо	3,9
0-17 нас хүртэлх хүүхдийн тоо	2,0
Гэр бүлийн ажил эрхэлдэг гишүүдийн тоо	1,0
Гадаад ажиллаж буй гишүүн байгаа эсэх	2,3%
Өрхийн тэргүүний дундаж нас	37
СУУЦНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ
Сууны талбайн хэмжээ	24,2
1 сууцанд амьдарч буй өрхийн тоо	1
Дундаж цалин	624,013₮
Хуримтлал байгаа эсэх	13,2%

ТҮРЭЭСЛЭЖ БҮЙ ӨРХҮҮД /ДҮҮРГЭЭР/	ӨРХИЙН ТОО
Баян-Өлгий	217
Баянхонгор	157
Говь-Алтай	25
Говь-Сүмбэр	166
Дархан-Уул	1,041
Дорноговь	489
Дорнод	1,429
Дундговь	36
Өвөрхангай	147
Сүхбаатар	62
Сэлэнгэ	270
Төв	88
Увс	36
Хөвсгөл	231
Хэнтий	330
<b>НИЙТ ӨРХИЙН ТОО</b>	<b>4,724</b>



ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ӨӨРИЙН ГАЗАР  
ДЭЭРЭЭ ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ХУВИЙН СУУЦ БАРИХ  
ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ





## 21 АЙМГИЙН ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3-5 ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ /НИЙТ ДҮНГЭЭР/

ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ 121,929 ӨРХ	ДЭД БҮТЭЦ БҮХИЙ СУУЦ БАРИХ 37,266 ӨРХ
ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ 32,048 ӨРХ	ОГТ ХЭРЭГЦЭЭГҮЙ 32,978 ӨРХ
ХАШАА БАЙШИН ХУДАЛДАЖ АВАХ 13,594 ӨРХ	АОС-ХАУС ХУДАЛДАЖ АВАХ 18,046 ӨРХ



